



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР”
ТӨААТУГ-ЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/75/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 268512 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn
Аудитор: Г.Ганбилэг
Утас: 261625 Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит
ХХК-ийн Захирал: О.Бурмаа
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Зөвлөмж.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГБНҮГ	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон Орон нутгийн өөрийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ө.ЛУВСАНРЕНЧИН ТАНАА

2025.03.17 № 07/1075

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартын шаардлага хангасан тул 2024-2027 онд үргэлжлүүлэн эзэмших эрх авсан. Тайлант онд үйлчлүүлэгч байгууллагаас авах үйлчилгээний орлого 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус газар нь 8,233.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааныхаа үр дүнгээр бүрэн санхүүжиж ажилласан байна.

Бусад асуудал

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувиар биелэлтийг хэрэгжүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,114,579,410.20	2,633,004,327.93
1.1.2	Дансны авлага	473,000.00	11,939,402.85
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	9,184,375.19	9,740,276.45
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	731,625,575.78	790,746,756.72
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	7,700,000.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,863,562,361.17	3,445,430,763.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,539,604,537.12	5,598,699,901.38
1.2.2	Биет бус хөрөнгө	704,532,476.99	696,863,320.31
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,244,137,014.11	6,295,563,221.69
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,107,699,375.28	9,740,993,985.64
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	0.00	21,319,246.00
2.1.1.3	Татварын өр	62,391,669.48	71,440,810.29
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	5,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	17,771,200.00	17,771,200.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	80,162,869.48	110,536,256.29
2.2	Өр төлбөрийн нийт дүн	80,162,869.48	110,536,256.29
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	7,955,637,235.90	7,955,637,235.90
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	757,597,449.00	757,597,449.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,248,329,224.49	3,248,329,224.49
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,057,767,155.91	1,057,767,155.91
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,991,794,559.50)	(3,388,873,335.95)
2.3.9.1	Өмнөх үеийн үр дүн	(2,705,313,138.34)	(2,991,794,559.50)
2.3.9.2	Тайлант үеийн үр дүн	(286,481,421.16)	(397,078,776.45)
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,027,536,505.80	9,630,457,729.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	10,107,699,375.28	9,740,993,985.64

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,151,148,540.71	8,398,003,137.71
2	Борлуулалтын өртөг	7,358,034,956.06	8,766,698,931.55
3	Нийт ашиг (алдагдал)	(206,886,415.35)	(368,695,793.84)
5	Хүүгийн орлого	145,124,640.65	248,852,196.93
8	Бусад орлого	2,193,282.89	540,909.09
9	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		5,445,587.67
10	Ерөнхий ба удирдлагын зардал	212,400,465.29	258,336,456.60
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(271,968,957.10)	(372,193,556.75)
19	Орлогын татварын зардал	14,512,464.06	24,885,219.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(286,481,421.16)	(397,078,776.45)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(286,481,421.16)	(397,078,776.45)
24	Орлогын нийт дүн	(286,481,421.16)	(397,078,776.45)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,955,637,235.90	757,597,449.00	3,248,329,224.49	1,057,767,155.91	(2,705,313,138.34)	10,314,017,926.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	7,955,637,235.90	757,597,449.00	3,248,329,224.49	1,057,767,155.91	(2,705,313,138.34)	10,314,017,926.9
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(286,481,421.16)	(286,481,421.16)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,955,637,235.90	757,597,449.00	3,248,329,224.49	1,057,767,155.91	(2,991,794,559.50)	10,027,536,505.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	7,955,637,235.90	757,597,449.00	3,248,329,224.49	1,057,767,155.91	(2,991,794,559.50)	10,027,536,505.8
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(397,078,776.45)	(397,078,776.45)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,955,637,235.90	757,597,449.00	3,248,329,224.49	1,057,767,155.91	(3,388,873,335.95)	9,630,457,729.35

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,885,939,154.73	9,244,692,308.50
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	7,748,755,192.00	9,103,027,249.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	137,183,962.73	141,665,059.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,557,903,676.10	8,930,756,678.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,581,498,326.00	3,225,813,660.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	747,170,062.90	854,495,634.78
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,642,594,948.75	1,836,902,608.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,554,544,201.69	1,800,781,675.21
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,418,760.00	2,402,700.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	608,000,719.96	799,981,846.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Шагнал урамшууллын зардал	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	419,676,656.80	410,378,553.75
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	328,035,478.63	313,935,629.72
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	145,124,640.65	248,852,196.93
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	145,124,640.65	248,852,196.93
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	125,444,604.66	44,362,908.92
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	125,444,604.66	44,362,908.92
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,680,035.99	204,489,288.01
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	347,715,514.62	518,424,917.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,766,863,895.58	2,114,579,410.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,114,579,410.20	2,633,004,327.93

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 он гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйл ажллагааны орлогын дүн (1)	7,298,466.5	7,346,516.0	8,647,396.2	(1,300,880.2)	117.7
Төсөвт байгууллагад үзүүлсэн ажил үйлчилгээний орлого	7,013023.3	7,061,850.0	8,233,613.9	(1,171,763.9)	116.6
Өмчийн орлого	44,249.8	34,150.0	27,922.6	6,227.4	81.8
Бусад орлого	96,068.7	80,516.0	137,007.6	(56,491.6)	170.2
Хүүгийн орлого	145,124.6	170,000.0	248,852.2	(78,852.2)	146.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)	7,584,947.9	8,275,785.8	9,049,920.6	(774,134.8)	109.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,506,869.7	8,158,658.1	8,970,179.4	(811,521.3)	109.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,561,084.4	4,345,020.3	4,375,510.0	(30,489.6)	100.7
Цалин хөлсний зардал	3,165,770.7	3,862,240.3	3,924,486.2	(62,245.9)	101.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	395,313.7	482,780.0	451,023.7	31,756.3	93.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,413,755.8	1,433,151.3	1,550,276.4	(117,125.1)	108.2
Гэрэл, цахилгаан	940,556.7	940,000.0	999,840.8	(59,840.8)	106.4
Түлш, халаалт	334,806.7	334,000.0	407,379.8	(73,379.8)	122.1
Цэвэр, бохир ус	138,392.4	159,151.3	143,055.4	16,095.5	89.9
Хангамж, бараа материалын зардал	518,425.1	546,790.3	641,087.0	(94,296.7)	117.2
Бичиг хэрэг	4,828.3	5,000.0	8,334.2	(3,334.2)	166.7
Тээвэр шатахуун	3,629.1	3,600.0	2,884.3	715.7	80.1
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	5,576.2	5,600.0	5,403.8	196.2	96.5
Ном, хэвлэл	415.9	450.0	181.8	268.2	40.4
Хог хаягдал зайлуулах	48,444.5	51,000.0	50,161.7	838.3	98.4
Хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016.4	6,000.0		6,000.0	
Бага үнэтэй, түргэн илэгдэх, аж ахуйн эд зүйлс	452,514.6	475,140.3	574,121.4	(98,981.1)	120.8
Нормативт зардал	2,920.3	3,358.3	21,157.0	(17,798.7)	630.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	187.5	215.6	245.2	(29.6)	113.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,732.8	3,142.7	20,911.8	(17,769.1)	665.4
Эд хогшил, урсгал засварын зардал	843,897.2	576,000.0	1,068,310.7	(492,310.7)	185.5
Багаж хэрэгсэл	17,069.4	25,000.0	23,778.1	1,221.9	95.1
Урсгал зардал	705,966.3	551,000.0	1,044,532.6	(493,532.6)	189.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,480.8	239,093.7	255,612.5	(16,518.8)	126.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,970.9	5,000.0	12,961.8	(7,961.8)	259.2
Даатгалын үйлчилгээ	477.2	550.0		550.00	
Тээврийн хэрэгсэлийн татвар	183.6	170.0	181.6	11.6	106.8
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	308.9	296.6	227.5	69.1	76.7
Татварын зардал	6,858.5	16,689.3	24,885.4	(8,196.1)	149.1
Газрын төлбөр	4,418.4	5,081.2	4,418.4	662.8	86.9
Мэдээлэл технологийн үйлчилгээ	9,488.1	11,306.6	10,358.1	948.5	91.6

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Харуул хамгаалалтын зардал	152,775.1	200,000.0	202,579.8	(2,579.8)	101.3
Бараа үйлчилгээний бусад зардал	958,300.9	1,015,244.1	1,012,182.3	3,061.8	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	31,705.0	61,589.1	46043.6	15,545.5	74.8
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	913,210.0	937,000.0	998,382.3	(61,382.3)	106.6
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	13,385.9	16,655.0	13,800.0	2,855.00	82.9
УРСГАЛ ШАЛЖҮҮЛЭГ	90,255.4	117,127.7	79,741.1	37,386.6	68.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,821.7	51,925.5	37,364.0	14,561.5	71.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,327.0	24,878.4		24,878.4	-
Шагнал, урамшуулал	9,106.7	40,323.8	42,377.1	(2,053.3)	105.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(190,773.6	(929,269.8)	(402,524.4)	(526,745.5)	
Авлага	8,697.7		21,679.7		
Өглөг	55,523.4		110,536.3		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын зорилго нь "Төрийн байгууллагуудын хуулиар тогтоогдсон зорилт, чиг үүргийг таатай нөхцөлд гүйцэтгэх бололцоог бүрдүүлэн өгөх буюу хэрэглэгчдийн сэтгэлд нийцэх нийтлэг үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүртээмжтэй үзүүлэхэд оршино" гэж тодорхойлон, дараах зүйлсийг эрхэмлэн ажилласан байна. Үүнд:

- Хэрэглэгч
- Байгууллага, хамт олон
- Мэдлэг, чадвар
- Сэтгэл, зүтгэл, гүйцэтгэлийг эрхэмлэх
- Цэвэр цэмцгэр, тав тухтай, эрүүл аюулгүй орчин

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээг нэгтгэж мэргэшсэн баг хамт олноор үйлчилгээг эрхлүүлэх нь төсөвт зардлыг хэмнэн, зарим ажил албан тушаалын давхардлыг арилгаж, санхүү, материал хангамжийн үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлснээрээ ач холбогдолтой шийдвэр болсон төдийгүй барилга, мужаан, цахилгаан, сантехникийн засвар үйлчилгээ, гэнэтийн аваар ослын ажлыг богино хугацаанд мэргэжлийн өндөр түвшинд хамтын хүчээр хийж гүйцэтгэдэг давуу талтай байна.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын дүрэмд тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг "төрийн захиргааны төв байгууллагуудад үзүүлэх нийтлэг үйлчилгээг хариуцан ажиллах" гэж тодорхойлжээ.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчин аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийг 100.0 хувь төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг

нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь компанийн захирлын 2019 оны А/03 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 366.7 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,114,579.4	2,633,004.3	518,424.9
Дансны авлага	9,657.4	21,679.7	12,022.3
Бараа материал	731,625.6	790,746.8	59,121.2
Урьдчилж төлсөн зардал тооцоо	7,700.0	0.0	(7,700.0)
Үндсэн хөрөнгө	7,244,137.0	6,295,563.2	(948,573.8)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,107,699.4	9,740,994.0	(366,705.4)
Дансны өглөг	0.0	21,319.2	21,319.2
Татварын өр	62,391.7	71,440.8	9,049.1
Урьдчилж орсон орлого	0.0	5.0	5.0
Бусад богино хугацаат өр төлбөр	17,771.2	17,771.2	0.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	80,162.9	110,536.3	30,373.4
Эздийн өмчийн дүн	10,027,536.5	9,630,457.7	(397,078.8)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	10,107,699.4	9,740,994.0	(366,705.4)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн данс 2,633.0 сая төгрөг болж 518.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь арилжааны банканд 900.0 сая төгрөг байршуулж, хугацаатай хадгаламж нэмэгдсэнээс шалтгаалсан.

Авлага данс 21.7 сая төгрөг болж 12.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түрээсийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлагын үлдэгдэлд түрээсийн авлага 11.9 сая төгрөг, татварын авлага 9.8 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 790.7 сая төгрөг болж 59.1 сая төгрөгөөр өссөн нь зайлшгүй шаардлагатай цэвэрлэгээ, нормын материалын нөөц бэлтгэсэн.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,295.6 сая төгрөг болж, 948.6 сая төгрөгөөр буурсан нь 44.4 сая төгрөгийн худалдан авалт, ТӨБЗГ-ын 2024 оны 443 дугаар тогтоолоор ЭЗХЯ-ны бүртгэлтэй 20.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас шилжүүлэн авснаар тус тус нэмэгдэж, 998.4 сая төгрөгийн элэгдэл байгуулж, ТӨБЗГ-ын 2024 оны 446 дугаар тогтоолын дагуу 17.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 30.4 сая төгрөгөөр өсөж 110.5 сая төгрөг байгаа нь түрээсийн барьцаа 17.8 сая төгрөг, дансны өглөг 21.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 9,630.5 сая төгрөг болж 397.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагынхаа 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 7,346.5 сая төгрөг, нийт зардлыг 8,275.8 сая төгрөг, 929.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 8,647.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 9,049.9 сая төгрөгийн зардал гарган 402.5 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөө 1,300.9 сая төгрөг буюу 17.7 хувиар давж биелсэн, зардал төлөвлөснөөс 774.1 сая төгрөгөөр илүү зарцуулсан.

Тайлант онд 402.5 сая төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөснөөс 526.7 сая төгрөгөөр бага байгаа нь борлуулалтын орлого 1,300.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зарим зардлуудыг хэмнэсэнтэй холбоотой байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ТӨААТҮГ нь тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн хүрээнд бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн асуудлаар нэр бүхий 11 байгууллагатай "Худалдах, худалдан авах гэрээ", "Засварын ажлын гэрээ" байгуулан 1,889.5 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөснөөс, өөрийн эх үүсвэрээс 1,697.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэн гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааг сайжруулахаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг "Аав ээжийн тэнгэрлэг буян аудит" ХХК-ийн ахлах аудитор О.Чулуунбаатар, аудиторын туслах Ю.Уртнасан нар гүйцэтгэж, аудитор Ц.Мөнхтөр, компанийн захирал О.Бурмаа нар анхан шатны чанарыг хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Г.Ганбилэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр 57 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 7,570.4 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцон тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын бичиг хэрэг, шуудан холбоо, байр ашиглалтай холбоотой зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласны дүнд 15.8 сая төгрөг, байр ашиглалтын зардлыг 16.1 сая төгрөг, ажил олгогчийн нийгмийн даатгалын зардлыг 31.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал 39.5 сая төгрөг, бусад зардал 13.2 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 21 төрлийн мэдээлэл бүхий 58,454.8 сая төгрөгийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын ТӨААТҮГ-ын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,080.0	1	2,080.0	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	2	2,080.0	2	2,080.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт илрүүлсэн 5.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт:

ААНОАТ-ын авлага 3.7 сая төгрөгийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдолоо өөрөө тодорхойлж хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө", 28.3.-т Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг Татварын ерөнхий хуулийн 49.1-д заасны дагуу шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах;

2. Илрүүлэлт:

Жилийн эцэст 2 аж ахуйн нэгжээс 21.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнаснаас 1 аж ахуйн нэгж байгууллагын 2.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх;

Дээрхи аудитын шийдвэрийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр												
Үүнээс												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ААНОАТ-ын авлага 3.7 сая төгрөгийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.	1	3,721.1					1	3,721.1				
Жилийн эцэст 1 аж ахуйн нэгж байгууллагын өглөгийн үлдэгдэл тооцоо нийлсэн актгүй 2.0 сая төгрөг байна.	1	2,000.0					1	2,000.0				
Дүн	2	5,721.1					2	5,721.1				

/мянаан төгрөгөөр/